

МӨНГӨНИЙ ТОЙМ

2016 оны 11 дүгээр сар

ХУРААНГУЙ:

- Тухайн сард М2 мөнгөний нийлүүлэлт 0.9 хувь буюу 109.0 тэрбум төгрөгөөр өсч 11.6 их наяд төгрөгт хүрчээ. Төгрөгийн харилцах, хадгаламж 236.3 тэрбум төгрөгөөр буурч, харин гадаад валютын харилцах 290.8 тэрбум төгрөг буюу 23.9 хувь, хадгаламж 105.3 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар өссөн байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол валютын харилцах өмнөх сараас 19.3 хувиар өссөн ч хадгаламж төдийлөн өөрчлөгдөөгүй байна.
- Тайлант сарын эцсийн байдлаар хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив -4585.9 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив 7029.4 тэрбум төгрөг байна.
- Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 305.6 тэрбум төгрөгөөр өсч 19.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 11.2 хувийг хугацаа хэтэрсэн, 5.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | | | | | |
|---|------------|-------------|-------------|------------|------------|------------|-------------|-------------|-------------|
| | 12-р сар | 12-р сар | 12-р сар | 3-р сар | 6-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | |
| Инфляци | | | | | | | | | |
| Улаанбаатар хотын | сарын | 1.7 | 0.6 | -0.2 | 0.3 | -0.5 | -0.9 | -1.2 | 0.7 |
| | оны эхнээс | 11.2 | 10.7 | 1.1 | 1.5 | 2.7 | 0.1 | -1.1 | -0.4 |
| | жилийн | 11.2 | 10.7 | 1.1 | 1.1 | 1.2 | -0.7 | -0.8 | -0.6 |
| Суурь | сарын | 1.3 | 0.4 | -0.1 | -0.4 | -0.1 | 0.3 | -0.1 | 1.0 |
| | оны эхнээс | 12.1 | 12.6 | 4.8 | -1.1 | -1.2 | -1.0 | -0.8 | 0.2 |
| | жилийн | 12.1 | 12.6 | 4.8 | 3.1 | 3.0 | 0.8 | 0.4 | 0.1 |
| Улсын | сарын | 0.7 | 0.8 | -0.2 | 0.5 | -0.3 | -0.6 | -0.7 | 0.5 |
| | оны эхнээс | 11.9 | 11.0 | 1.9 | 1.7 | 2.9 | 0.6 | -0.1 | 0.4 |
| | жилийн | 11.9 | 11.0 | 1.9 | 1.7 | 1.6 | -0.1 | -0.1 | 0.2 |
| Мөнгө, санхүүгийн сектор | | | | | | | | | |
| Нөөц мөнгө, сая ₮ | | 3,335.5 | 3,426.5 | 2,459.6 | 2,360.7 | 3,526.1 | 3,096.4 | 2,933.9 | 3,250.4 |
| сарын өөрчлөлт, хувиар | | 18.1 | 27.9 | 17.9 | 2.3 | 10.0 | -4.9 | -5.2 | 10.8 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | 54.0 | 2.7 | -28.2 | -4.4 | 49.9 | 28.5 | 33.8 | 55.7 |
| М2 мөнгө, сая ₮ | | 9,454.9 | 10,635.8 | 10,050.2 | 10,113.7 | 11,188.2 | 11,450.1 | 11,506.3 | 11,615.3 |
| сарын өөрчлөлт, хувиар | | 3.9 | 7.1 | 2.5 | 1.0 | 5.0 | 1.6 | 0.5 | 0.9 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | 24.2 | 12.5 | -5.5 | 2.1 | 11.4 | 15.3 | 16.2 | 18.4 |
| Бусад хадгаламж, сая ₮ | | 7,361.7 | 8,819.1 | 8,364.8 | 8,530.0 | 9,206.8 | 9,519.7 | 9,499.7 | 9,776.0 |
| сарын өөрчлөлт, хувиар | | 1.2 | 7.0 | 1.4 | 0.4 | 3.3 | 1.7 | -0.2 | 2.9 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | 27.4 | 19.8 | -5.2 | 0.9 | 9.9 | 14.4 | 14.9 | 18.5 |
| Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮ | | 841.1 | 809.7 | 706.7 | 658.6 | 839.2 | 795.8 | 806.5 | 768.7 |
| сарын өөрчлөлт, хувиар | | 4.6 | 5.3 | -0.5 | 0.5 | 6.5 | -2.6 | 1.3 | -4.7 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | 1.5 | -3.7 | -12.7 | -6.3 | 11.0 | 3.6 | 9.0 | 8.2 |
| Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮ | | 12,570.6 | 16,566.6 | 17,915.5 | 18,414.3 | 18,411.2 | 19,240.1 | 19,471.0 | 19,776.7 |
| сарын өөрчлөлт, хувиар | | | | 0.5 | 1.5 | 1.7 | 0.6 | 1.2 | 1.6 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | -99.8 | 31.8 | 8.1 | 8.1 | 8.1 | 8.0 | 9.7 | 10.9 |
| Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮ | | 10,771.2 | 12,503.5 | 11,706.6 | 11,840.1 | 12,031.3 | 12,490.9 | 12,566.0 | 12,718.5 |
| сарын өөрчлөлт, хувиар | | -99.9 | -1.2 | -1.6 | 1.7 | 5.1 | 0.4 | 0.6 | 1.2 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | -99.8 | 16.1 | -6.4 | -3.5 | 0.6 | 4.6 | 5.4 | 6.9 |
| Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮ | | 566.0 | 625.7 | 869.8 | 967.9 | 1,035.6 | 1,119.3 | 1,140.1 | 1,167.0 |
| сарын өөрчлөлт, хувиар | | -99.9 | 0.9 | 0.5 | 6.2 | -2.6 | -0.6 | 1.9 | 2.4 |
| жилийн өөрчлөлт, хувиар | | -99.8 | 10.6 | 39.0 | 37.7 | 33.8 | 31.3 | 30.9 | 34.8 |
| Мөнгөний үржүүлэгч | | 2.83 | 3.10 | 4.09 | 4.28 | 3.17 | 3.50 | 3.46 | 3.46 |
| Хүү | | | | | | | | | |
| Хадгаламжийн ЖДХ | | 12.1 | 12.5 | 13.3 | 13.3 | 13.3 | 13.2 | 13.3 | 13.3 |
| Хадгаламжийн бодит хүү* | | 0.9 | 1.8 | 12.2 | 12.2 | 12.1 | 13.8 | 14.0 | 13.9 |
| Зээлийн ЖДХ** | | 17.4 | 19.5 | 19.1 | 19.7 | 19.1 | 20.1 | 20.2 | 20.6 |
| Зээлийн бодит хүү* | | 6.2 | 8.9 | 18.0 | 18.6 | 18.0 | 20.8 | 21.0 | 21.2 |
| Ипотекийн зээлийн хүү | | 9.90 | 9.90 | 8.82 | 8.81 | 7.74 | 8.68 | 9.06 | 9.17 |
| ТБҮЦ-ны ЖДХ | | 10.5 | 12.1 | 13.0 | 12.0 | 10.5 | 16.0 | 16.2 | 16.1 |
| Бодлогын хүү | | 10.50 | 12.00 | 13.00 | 12.00 | 10.50 | 15.00 | 15.00 | 15.00 |
| БХЗ-ын ЖДХ | | 8.91 | 12.20 | 11.84 | 12.55 | 11.33 | 15.87 | 15.51 | 15.96 |

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Төгрөгийн зээлийн жингэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

Тухайн сард M2 мөнгөний нийлүүлэлт 0.9 хувь буюу 109.0 тэрбум төгрөгөөр өсч 11.6 их наяд төгрөгт хүрчээ.

M1 мөнгө 167.3 сая төгрөгөөр буурахад төгрөгийн харилцах 116.5 тэрбум төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлжээ. 2016 оны 11 дүгээр сарын байдлаар M1 мөнгө 1839.3 сая төгрөг болж, мөнгөний нийлүүлэлт (M2)-д эзлэх хувь нь 1.6 нэгж хувиар буурч 15.8 хувьтай тэнцэж байна.


Бусад хадгаламж, харилцах тухайн сард 276.2 тэрбум төгрөгөөр өсч 9776.0 тэрбум төгрөгт хүрсэн. Бусад хадгаламжийн өсөлтөд валютын харилцах, хадгаламжийн өсөлт гол нөлөө үзүүлэв. Тодруулбал, гадаад валютын хадгаламж 105.3 тэрбум төгрөг буюу 4.1 хувь, гадаад валютын харилцах 290.8 тэрбум төгрөг буюу 23.9 хувиар өсчээ.

Гадаад валютын хадгаламжийн өсөлтөд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан нь гол нөлөө үзүүлж байгаа бөгөөд ханшийн нөлөөг арилгаж тооцвол валютын харилцах өмнөх сараас 19.3 хувиар өссөн ч хадгаламж төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Гадаад валютын харилцах нэмэгдэхэд хувийн хэвшлийн харилцахын өсөлт гол нөлөө үзүүлжээ.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа, тэрбум ₮




Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт (тэрбум ₮)



Гадаад, дотоод актив

- Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл, 2016 оны 11 дүгээр сарын байдлаар хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 78.2 тэрбум төгрөгөөр буурч -4585.9 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив 30.8 тэрбум төгрөгөөр өсч 7029.4 тэрбум төгрөг байна.
- Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив 270.0 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 348.2 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлөв.
- Хадгаламжийн байгууллагын дотоод активын дийлэнхийг зээл бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх сараас хувийн хэвшил болон


Зураг 3. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



иргэдэд олгосон зээл харгалзан 84.3 тэрбум төгрөг, 71.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Тайлант сард арилжааны банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаас 493.8 тэрбум төгрөгөөр буурч, богино хугацаатай Засгийн газрын үнэт цаас 313.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ нь хадгаламжийн байгууллагуудын Засгийн газраас авах цэвэр авлага 185.4 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.
- Тайлант сард нөөц мөнгө 10.8 хувь буюу 316.5 тэрбум төгрөгөөр өсч 3250.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд банкуудын Төв банк дахь гадаад валютын харилцах, хадгаламж 354.3 тэрбум төгрөг (16.6%)-өөр өссөн нь гол нөлөө үзүүлэв.

Зураг 4. Нөөц мөнгө




Санхүүгийн байгууллагын зээл


Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 305.6 тэрбум төгрөгөөр өсч 19.8 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 39.5 хувийг иргэд, 39.4 хувийг хувийн хэвшил, 21.2 хувийг улсын байгууллагуудад олгосон зээл эзэлж байна. Тухайн сард зээлийн үлдэгдэл өсөхөд иргэд болон улсын байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдэл харгалзан 89.3 тэрбум төгрөг, 83.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсч 11.2 хувьд хүрчээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлд хугацаа хэтэрсэн зээл 7.6 хувь, чанаргүй зээл 9.1 хувийг эзэлж байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.7 хувийг эзэлж байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн дийлэнхийг хувийн хэвшилд олгосон зээл бүрдүүлж байна.

Зураг 5. Санхүүгийн байгууллагуудын зээл



Зураг 6. Санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 528.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 61.2 хувийг овернайт зээл, 19.1 хувийг репо арилжаа, 11.1 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 8.6 хувийг банк хоорондын хадгаламж бүрдүүлжээ.

Банкууд 2016 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 2404.4 тэрбум төгрөгийг Монголбанк дахь харилцах дансандаа төвлөрүүлжээ.

Зураг 7. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Тайлант сарын эцэст төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж жилийн хүү 2.8 хувь, төгрөгийн хадгаламжийн хүү 13.3 хувь байна. Харин гадаад валютын хадгаламжийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурч 6.0 хувь болжээ.

Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсч 20.6 хувь болов. Харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн дундаж зээлийн хүү өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсч 18.5 хувь байна.

Банк хоорондын захын хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсч 15.96 хувьд хүрчээ. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй бол Засгийн газрын 12 долоо хоногтой үнэт цаасны хүү 0.3 нэгж хувиар өсч 17.0 хувьд хүрэв.


Зураг 8. Хүү



Валютын ханш

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3.9 хувь буюу 92.4 төгрөгөөр суларч 2466.64 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2434.32 төгрөг байв. Тайлант сарын эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 3.3 хувиар буурсан буюу төгрөгийн ханш суларсан байна.


Зураг 8. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Инфляци

2016 оны 11 дүгээр сарын инфляци улсын хэмжээнд 0.5 хувь байсны 0.6 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, түлшний үнийн өсөлт, -0.15 нэгж хувийг хүнсний барааны үнийн өөрчлөлт эзэлж байна. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 2.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Хүнсний барааны үнийн өөрчлөлтөд өмнөх онуудын адил улирлын хэлбэлзэл ажиглагдаж байна.

Зураг 9. Улсын сарын инфляци



Жилийн инфляци улсын хэмжээнд 2016 оны 11 дүгээр сарын байдлаар 0.2 хувь байна. Үүний 0.5 нэгж хувийг хүнснээс бусад барааны, -0.3 нэгж хувийг хүнсний барааны үнийн өөрчлөлт бүрдүүлж байна.

Зураг 10. Улсын жилийн инфляци

